



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/38

Мандалговь

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл
нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг
шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 59, 60, 61, 62, 63 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 84, 101, 122 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2022-2024 он хүртэл эрүүл мэндийн газрын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөр батлагдсантай уялдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг байгууллагын жил бүрийн төсөвт тусгаж байхыг ерөнхий нягтлан бодогч (Т.Одонцэцэг), Хүний нөөц хангалт сургалт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн (Р.Мөнхбаясгалан) нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг байнгын удирдлага зохион байгуулалтаар ханган хариуцан ажиллаж жилийн эцэст тайлагнаж ажиллахыг эдийн засагч (Г.Болдмаа), хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын болон гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Оюунчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Алтантөгс* Б.АЛТАНТӨГС

